- Campus –н орчны холболтонд онцгой ач холбогдолтой IP –д суурилсан камерын үйлчилгээнүүд
- Нэг шугамын бүртгэл, судалгаа шинжилгээний үйлчилгээнүүд

- Электрон сургалтын төвийн орчин
- Онлайн сургалтын горим

### 2.1.3 БЭЭЖИНГИЙН ЖИРИЙН ИХ СУРГУУЛИЙН УТАСГҮЙ CAMPUS СҮЛЖЭЭ



Зураг 2.6 Бээжингийн Жирийн Их Сургууль


#### **Шийдлийн тойм**

Сүлжээний маш олон борлуулагчтай харилцсаны дараа Бээжингийн Жирийн Их Сургууль Ruijie сүлжээний ухаалаг утасгүй switching –н сүлжээний шийдлийг сонгосон бөгөөд үе 1 ба үе 2 –д бүхэлд нь 658 ухаалаг менежментийн WAP –уудыг тараан байрлуулсан. Энэ утасгүй сүлжээ нь том хэмжээтэй бөгөөд олон барилга, сургалтын хэсэг, байгууллага, судалгаа ба шалгалтын хэсэг мөн задгай газруудын талбайг жигд бүрхэнэ. Эдгээр хэсгүүд хооронд , байгууллагын хэсгүүд ба хурлын хэсгүүд, их сургуулийн хэвийн ажиллагааг хариуцах гол хэсгүүд байдаг.

Мэдээллийн төв нь иж бүрэн илүү 5 MX-200R -н утасгүй холбоогоор суурь сүлжээг оролдог. RingMaster -н сүлжээний менежмент платформын төвлөрсөн хяналт ба менежменттэй бөгөөд эх бэрхшээлүүд ба андуурлуудыг бүрэн арилгасан. Сүлжээ нь бүрэн холбогдсон ба жинхэнэ баталгаажуулалтын гарцтай нэгтгэгдсэн, тэгэхлээр Бээжингийн Жирийн Их Сургуулын campus мэдээллийн гол хэсэг нь болдог.

Зураг 2.7 Бээжингийн Жирийн Их Сургуулийн утасгүй campus сүлжээний загвар.





### Шийдлийн онцлог шинжүүд

Бээжингийн Жирийн Их Сургуулийн утасгүй холбооны сүлжээг хагас жилд хэрэглэхэд тавьсан байна. Зохистой төлөвлөлт ба тогтвортой хэрэгжилтийн улмаас энэ том хэмжээний утасгүй сүлжээ ажиллаж эхэлсэн ба сүлжээний төв нь эмх цэгцгүй болоогүй. Үүнд их сургууль нилээд сэтгэл хангалуун байсан. Тэднийг -г дараахад нарийн мэдээлэл тайлбарладаг, "scale", "innovation", "integration" ба "expansion", байх тэр, University 4 үг сайн долгион сүлжээний бүтэц -руу тэдний бодол ба хэсгүүдийг тайлбарлах гэж итгэсэн

Их сургууль утасгүй сүлжээний байгууламжид чиглэсэн мөн түүний онцлог шинжүүдийг тайлбарласан "хэмжээ", "шинэчлэл", "нэгдэл" болон "өсөн нэмэгдэлт" гэсэн 4 үгэнд найдсан. Тэдгээрийг дараах байдлаар дэлгэрэнгүй тайлбарлавал:

1. Хэмжээ: Бээжингийн Жирийн Их Сургуулийн утасгүй холбооны campus сүлжээ нь 2008 онд байгуулагдсан бөгөөд WAPs -н хамгийн том тоотой утасгүй холбооны campus сүлжээ байсан. Энд нийт 5 утасгүй холбооны switch ба 700 – аад WAP байсан. Түүний барилгын туршилт Хятадын боловсролын салбарт том хэмжээтэй утасгүй холбооны сүлжээний байгууламжид судалгааны ихээхэн туршлага олж авах, гэвч сүлжээний дараагийн өсөлтийг шууд хангаж чадахгүй.
2. Хөгжил: Хамгийн сүүлийн ухаалаг утасгүй холбооны switching -н технологи нь өргөн сүлжээг эзэмшдэг. Энэ нь сүлжээний урсгалыг боломжийн хуваарилах бөгөөд ирээдүйн 802.11n эрин үеийн өндөр зурасын өргөнийг дэмжих ба энэ нь утасгүй холбоог сольж өөрчлөлгүйгээр хэрвээ шаардлагатай бол зөвхөн WAPs

нэмнэ. Энэ нь утастай холбооны сүлжээтэй адилгүй бөгөөд гол төхөөрөмжийг шинэчилж байхад л хангалттай.

3. Нэгдэл: Утастай ба утасгүй сүлжээг хоёуланг нь нэгтгэн баталгаажуулж болно. Их сургуулийн факультетууд ба бүх оюутнууд нэгэн жигд GUI –н баталгаажилтаар campus сүлжээнд хүрч чадна. Тэгэхлээр утасгүй холбооны сүлжээ нь campus сүлжээтэй хялбархан нэгтгэгдэж байна.
4. Өсөн нэмэгдэлт: Бээжингийн Normal их сургуулийн утасгүй холбооны campus сүлжээ нь утасгүй холбооны дуу , видео хяналт , утасгүй холбооны байршил ба бусад технологиудыг дэмжинэ. Сүүлийн үед , зөвхөн өргөтгөлийн програмуудыг дуусгахын тулд тохирох програм ба тохиргоог нэмэх шаардлагатай байна. Энэ нь эргэлзээгүй утасгүй холбооны жинхэнэ зорилгод зориулж хамгийн сайн платформоор хангана.

“Утасгүй холбооны сүлжээний туршлагатай манай сургуульд тавтай морилно уу” гэж сүлжээний төвийн багш нар сэтгэл хангалуун хэлж байна.

#### 2.1.4 СЕНЕГАЛИЙН ДАКАРЫН ИХ СУРГУУЛЬ



Зураг 2.8 Дакарын Их Сургууль


Энэхүү сургууль нь 1957 онд байгуулагдсан бөгөөд 1099 профессор судлаач, 1171 техникийн болон захиргааны ажилтан, 66 улс үндэстний 43764 оюутантай.

Тус сургууль нь Дэлхийн Банкны Институдийн санхүүжилтээр 2000 оноос эхлэн campus сүлжээтэй болсон. Одоо кампус сүлжээ нь их сургуулийн төсвөөр санхүүждэг.


#### **Одоогийн сүлжээний архитектур нь:**

- Их Сургуулийн бүх салбар хэсэг нь Кампус Сүлжээнд холбогдсон

- Их Сургуулийн бүх салбар хэсэг нь Интернетээр хангагддаг
- 6 км –ээс илүү шилэн кабель татсан
- Суурь сүлжээ нь 200 Mbps –н 3 хэсгээс бүрдэнэ / ойроцоогоор 3 км/
- 2 Mbps –н итернетийн урсгалтай
- Утасгүй сүлжээ нь 5 байрлалаас холбогддог / хоорондын зай нь хамгийн ихдээ ойролцоогоор 3 км/



Зураг 2.9 Одоогийн Кампус Сүлжээний Загвар



Зураг 2.10 Салбаруудын сүлжээний холболт

### Тонг төхөөрөмж ба бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- Юуны өмнө Cisco төхөөрөмжүүдийг сүлжээндээ хэрэглэнэ / 2 Router, 1 Firewall pix, 50 гаруй switch /.
- Сүлжээндээ 16 сервер, 3000 зангилааг холбоно
- 75KBт –н цахилгаан үүсгүүрээр энэхүү дэд бүтцийг хангана.

### Сүлжээний үйлчилгээнүүд:


- Кампус сүлжээнд хэрэглэж болох үйлчилгээнүүд:
  - E-мэйл үйлчилгээнүүд / 2500 гаруй/
  - Веб үйлчилгээ
  - Дотоод ба Улсын үйлчилгээнд зориулсан DNS үйлчилгээ
  - FTP үйлчилгээ
  - ISDN –н видео хурлын 1 үйлчилгээ
  - Нууцлал хамгаалалт: firewall, радиус, антиспам, антивирус г.м

### Одоогийн загварын хязгаарлалт:

- Эхэндээ сүлжээг нитернетэд хандатгүй 300 PC –тэй байхаар төлөвлөсөн бөгөөд энэ нь хуучирсны улмаас интернетэд хамдалттай 3000 PC –тэй болгосон.
- Тэлэлт нь заримдаа удирдагддаггүй
- Сүлжээний нууцлалын зарим асуудал



- Сүлжээний тоног төхөөрмж нь хуучирсан
- Интернетийн хяналт нь




Зураг 2.11 Их Сургуулийн сүлжээний ачаалал

- Интернет холболт нь өндөр үнэтэй / сард 1500\$/
- Хөгжлийн төлөвлөлттэй зохицож чадахгүй
  - 1 оюутанд 1 компьютер / ЗГ –н төсөл /
  - 1 багшд 1 компьютер / Их Сургуулийн төсөл /
- Сүлжээний төхөөрөмж нь VLAN –н замчлалыг зөвшөөрдөггүй.

#### Сүлжээний загварын хөгжил:

- Зурвасын өргөнийг 2 Mbps -10 Mbps хүргэх
- Дотоод сүлжээний дизайныг мэдээлэл солилцоход дөхөм болгох
- Одоогийн архитектурын нууцлалыг шинэчлэх
- VLAN –г замчлах боломж
- Бүх оюутнуудыг интернетийн тасралтгүй үйлчилгээгээр хангах

Зураг 2.12 Кампус сүлжээний загварын хөгжил



#### Шинэ үйлчилгээнүүд:

- Voice over IP

- Видео хурлын үйлчилгээ
- Их сургуулийн клиникд теле эмнэлгийн үйлчилгээ
- E-сургалт

## 2.2 Монголын их дээд сургуулиуд

### 2.2.1 Манай улсын их дээд сургуулиуд тэдгээрийг хотхоноор хөгжүүлэх чиглэл.



Зураг 2.13 Мэдээлэл харилцаа холбооны өндөр технологийн паркийн ерөнхий архитектур загвар

Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн гол тулгуур нөхцөл нь хүний хүчин зүйл гэж үзэн бодлого, үйл ажиллагааныхаа агуулга, зорилгыг “Хүний төлөө хөгжил, хөгжлийн төлөө хүн” хэмээн тодорхойлсон болно.

Дээд боловсролтой мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэдэг үндэсний их сургуулиудын бүтцийг оновчтой болгож, сургалт, судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн холбоог бэхжүүлэн, дэлхийн тэргүүлэх их сургуулиудын жишгийг баримжаалан өөрчлөх нь Монгол Улсын өнөөгийн хөгжлийн бодит шаардлага болж байна.

Үндэсний их сургуулиудын үйл ажиллагаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, чанартай сургалтад тулгуурлан улс орны эдийн засаг, нийгэм, соёлын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий судалгаа шинжилгээнд түлхүү чиглэсэн, бодит өгөөжтэй, үр ашигтай байх ерөнхий зарчмыг Засгийн газраас баримталж байна.

Дээд боловсролын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх цогц арга хэмжээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь төрийн бодлогын хүрээнд их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх явдал юм.

Их, дээд сургуулиудын профессор, багш, судлаачид, магистрант, докторант, Шинжлэх ухааны академийн хүрээлэн, төвүүдийн эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хамтран хийдэг, гарсан үр дүнг нь бизнесийн болон санхүүгийн байгууллагатай хамтран үйлдвэрлэлд шуурхай нэвтрүүлэхэд энэхүү хотхон байгуулах бодлого чиглэгдэнэ.

Одоогоор манай улсын томоохон гэсэн их дээд сургуулиуд нь төдийлөн байршилын хувьд ч тэр сүлжээний архитектур дизайны хувьд ч хотхоны шаарлагад нийцэхгүй байгаа. Энэхүү их дээд сургуулиудыг хотхон болгон хөгжүүлэх бодлогыг Засгийн газраас дэмжиж байгаа нь олон улсын түвшинд нийцсэн чанарлаг сургуулиудыг цогцлоогоод зогсохгүй оюутан бидний сурч боловсрох нөхцөлийг илүү сайн хангаж чадна. Ингэснээр дэлхийн жишигт нийцсэн боловсон хүчин бэлтгэгдэх улмаар улс орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

Олон улсын түвшинд сургалтын чанараар хүлээн зөвшөөрөгдөх, үндэсний хэмжээнд тэргүүлэх их сургуулиудыг бий болгох зорилгоор нэн тэргүүнд төрийн өмчийн их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх шийдвэр Засгийн газраас гаргасан. Доорхи хүснэгтэд төрийн өмчийн томоохон их дээд сургуулийн 2009 оны байдлын судалгаагаар гаргасан товч мэдээллийг харууллаа.

Хүснэгт 1 Монголын төрийн өмчийн томоохон их дээд сургуулиуд

№	СУРГУУЛИЙН НЭР	СУРГУУЛИЙН БҮТЭЦ, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ	ОДОО СУРАЛЦАГЧ Бакалавр, Магистрант, Докторант	ХАЯГ, БАЙРШИЛ, УТАС, ВЭБ САЙТ	ТАЙЛБАР
1	ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ (ШУТИС)	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын инженерийн</li> <li>- Компьютерийн техник, менежментийн</li> <li>- Хүнсний биотехнологи</li> <li>- Гадаад хэлний</li> <li>- Геологийн</li> <li>- Үйлдвэр технологи, дизайны</li> <li>- Механик инженерийн</li> <li>- Уул, уурхайн</li> </ul>	20222 992 642	УБ, СБДүүрэг, Бага тойруу-34, УБ-46, ш/х-520 324121, 324590, 324319, 324295 www.must.ed u.mn	Оройн ангид 2440 хүн суралцдаг Бүрэлдхүүн 13 сургууль, Дархан, Орхон, Сүхбаатар, Өвөрхангай салбар сургуультай Хичээлийн 7 байр, оюутны байруудтай

		<ul style="list-style-type: none"> <li>- Эрчим хүчний инженерийн</li> <li>- Математикийн</li> <li>- Материал технологийн</li> <li>- Хүмүүнлэгийн</li> <li>- Мэдээлэл холбоо технологийн</li> </ul>			
2	МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ-ЫН ИХ СУРГУУЛЬ (МУБИС)	<ul style="list-style-type: none"> <li>- Компьютер, мэдээллийн технологийн</li> <li>- Математик статистикийн</li> <li>- Монгол судлалын</li> <li>- Байгалын ухааны</li> <li>- Дүрслэх урлаг, технологийн</li> <li>- Багшийн</li> <li>- Боловсрол судлалын</li> <li>- Физик технологийн</li> <li>- Биеийн тамирын дээд</li> <li>- Гадаад хэлний</li> <li>- Сургуулийн өмнөх боловсролын</li> <li>- Түүх, нийгмийн ухааны</li> </ul>	8356 616 169	УБ, СБДүүрэг, Бага тойруу-14, 322705, 311547, 320339, 323102 www.msue.edu.nb	Орой, эчнээ ангитай, 12 бүрэлдэхүүн сургуультай Хичээлийн 7, оюутны 5 байртай. Ховд аймгийн Биеийн тамирын дээд сургууль, Архангай, Баян-Өлгий аймаг дахь багшийн коллежууд нь тус сургуулийн харъяанд багтдаг
3	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ (МУИС)	<ul style="list-style-type: none"> <li>- Математик, Компьютерийн</li> <li>- Мэдээллийн технологийн</li> <li>- Физик, Электроникийн</li> <li>- Биологийн Факультет</li> <li>- Газарзүй, Геологийн Факультет</li> <li>- Олон Улсын Харилцааны</li> <li>- Монгол Хэл Соёлын</li> </ul>	10877 1500 547	УБ, СБДүүрэг, Их Сургуулийн гудамж-1 976-11-320669, 320159, 320160 www.num.edu.mn	Орой, эчнээ ангитай, Улаабаатар хотод 12 бүрэлдэхүүн сургууль, факультет, Орхон, Завхан аймагт салбар сургуультай Хичээлийн 5 байртай, Гадаад оюутны байранд 160



		<ul style="list-style-type: none"> <li>- Гадаад хэл Соёлын</li> <li>- Нийгмийн Шинжлэх Ухааны</li> <li>- Хуульзүйн</li> <li>- Эдийн засгийн</li> <li>- Химийн Факультет</li> </ul>			хүн, дотоодын оюутны 4 байранд 1200 оюутан хүлээн авах багтаамжтай
4	ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ (ХААИС)	<ul style="list-style-type: none"> <li>- Мал эмнэлэг биотехнологийн</li> <li>- Биологийн нөөцийн менежментийн</li> <li>- Инженерийн</li> <li>- Агробиологийн</li> <li>- Эдийн засаг бизнесийн</li> <li>- Байгалын ухааны</li> <li>- Экологи технологи хөгжлийн</li> </ul>	7762 817 228	УБ, ХУДүүрэг, Зайсан-153 976-11-341770, 341592, 341711 www.msua.edu.mn	Эчнээ ангитай оюутны байруудтай
5	ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ (ЭМШУИС)	<ul style="list-style-type: none"> <li>- Анагаах ухааны</li> <li>- Улмажлалт анагаахын</li> <li>- Нүүр ам судлалын</li> <li>- Эм зүйн</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн</li> <li>- Биоанагаахын</li> <li>- Сувилахуйн сургууль</li> </ul>	4207 496 173	УБ, СБДүүрэг, Чойдогийн гудамж-3, 321249, 321834,312059, 323052 http://www.hs.um.edu.mn	Эчнээ оройн ангитай Бүрэлдэхүүн 7 сургууль, Сүхбаатар, Говь-Алтай, Дархан, Дорноговь аймагт харъя сургуультай Хичээлийн төв байр, 600-аад ортой оюутны байртай.
6	БАТЛАН ХАМГААЛ АХЫН ИХ СУРГУУЛЬ (БХИС)	<ul style="list-style-type: none"> <li>- Батлан хамгаалахын урирдлагын академи</li> <li>- Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн</li> <li>- Удирдлага</li> </ul>	1961 127 77	УБ, БЗДүүрэг, Улаанхуаран , 458673, 460650, 451364, 460648 www.dum.mn	Эчнээ ангитай УТДС –н энгийн ангийн төлбөр 300000₮

		технологийн дээд - Цэргийн дээд - Ахлагчийн - Цэргийн хөгжмийн			
--	--	---	--	--	--

**Их сургуулиудын хотхонд тавигдах ерөнхий шаардлага:**

- Архитектур, дизайны оновчтой шийдэл бүхий олон улсын жишигт нийцсэн орчин үеийн иж бүрэн барилга, байгууламжийн цогцолбороос бүрдсэн байна.
- Хичээлийн байр болон бусад зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, оюутан, эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байгууламж болон тоноглолтой байна.
- Сургалтын техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж нь орчин үеийн сургалт, судалгааны шаардлагад нийцсэн байна.
- Эрдэм шинжилгээний хүрээлэн, лаборатори, бизнес-үйлдвэрлэл-технологийн инкубатор, технологи дамжуулах төв, технологийн паркттай байна.
- Өндөр хурдны интернет сүлжээтэй, зайны сургалт явуулах орчин бүрдсэн байна.
- Сургалт-эрдэм шинжилгээний номын сантай байна.
- Нийт багш, оюутны 40-өөс доошгүй хувь нь байрлах дотуур байр болон орон сууцтай байна.
- Ажиллагсад, оршин суугчид болон багш, эрдэм шинжилгээний ажилтан, оюутанд зориулсан нэгдсэн эмнэлэгтэй байна.
- Багш, эрдэм шинжилгээний ажилтан, ажиллагсад, оюутны чөлөөт цагаа өнгөрүүлэх соёлын ордон, клубтэй байна.
- Нийтийн биеийн тамир, спортын цогцолбортой байна.

**Их сургуулиуд болон хотхоны байршил, шийдвэрлэх арга хэмжээний чиглэл**

Их сургууль болон хотхоныг дараахь байдлаар төлөвлөж хөгжүүлнэ:

- Эхний ээлжинд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хотхоныг нийслэлийн Налайх дүүргийн зүүн урд хэсэгт орших “Шивэрт”-ийн хөндийд 1000 гаруй га газарт “Оюуны” хот байдлаар “Silicon valley”-гийн хамт байршуулна.
- Төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллеж нь дангаараа буюу нэгдэж их сургуулийн хотхон байгуулах тохиолдолд хөрөнгө оруулагчийн сонголт хийсэн газарт байрших боломж олгоно.
- Геологи, уул уурхайн их сургуулийн хотхоныг Орхон аймгийн төвд “Эрдэнэт” үйлдвэр ХХК болон хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж эхлүүлнэ.
- Ховд аймаг дахь Ховд их сургуулийг баруун бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв болгон хөгжүүлнэ.
- Дорнод аймаг дахь Дорнод дээд сургуулийг зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв болгон хөгжүүлнэ.

- Дархан-Уул аймгийн төвд техникийн чиглэлийн их сургуулийг байгуулж хөгжүүлнэ.
- Төрийн өмчийн бусад их, дээд сургуулийг хотхоноор хөгжүүлэх асуудлыг орон нутгийн оролцоотойгоор үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- Төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн нэгдэх эсхүл хамтарч хотхоноор хөгжих санаачилгыг төрөөс дэмжиж хотхон байгуулах эдэлбэр газар олгох, дэд бүтцийг байгуулахад бодит дэмжлэг үзүүлнэ.

#### Санхүүгийн эх үүсвэр:

Хотхон байгуулж хөгжүүлэх санхүүжилтийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр бүрдүүлнэ. Хувийн хэвшлийн зүгээс хотхоны багш, оюутны байрны дийлэнх хэсэг, үйлчилгээний чиглэлийн бүх байгууллагуудыг барьж байгуулан ажиллуулна.

Хүснэгт 2 Хотхоны объектууд болон санхүүжилтийн үндсэн эх үүсвэр.

Объект	Төрийн /хувиар/ санхүүжилт	Хувийн хэвшлийн санхүүжилт /хувиар/
Хичээл, сургалтын байр	100	-
Лабораторийн байр	100	-
Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн байр	100	-
Номын сан-мэдээллийн төв	100	-
Биеийн тамир, спортын барилга, талбай	100	-
Дэд бүтэц	100	-
Багш, оюутнуудын байр	10	30
Хотхоны хамгаалалт	50	50

Нийтийн хоол, худалдаа, хими цэвэрлэгээ, үсчин, гоо сайхан, зурагчин зэрэг ахуйн үйлчилгээ		100
--	--	-----

Мөн дараах байдлаар санхүүжилтийг бүрдүүлнэ. Үүнд:

- Их сургуулиудын ашиглаж байгаа зарим үл хөдлөх хөрөнгийг борлуулсан орлого.
- Оон улсын хөнгөлөлттэй зээл, тусламж.
- Их сургуулиудын үйл ажиллагаанаас олсон орлогын тодорхой хэсэг.
- Хүний хөгжил сангаас боловсролд зориулсан хөрөнгө.
- Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө.
- Төгсөгчдөөс өгсөн хандив, тусламж.
- Гадаадын их, дээд сургууль, хувь хүмүүсээс өгсөн буцалтгүй тусламж, хандив.
- Гадаадын хөрөнгө оруулалт.

**Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл хэрэгжсэний үр дүнд:**

- Дээд боловсролын хөрвөх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар дээшилж, олон улсын тэргүүлэх их сургуулиудын жишигт ойртох нөхцөл бүрдэнэ.
- Эдийн засгийн хөгжлийн бодит хүч болох оюутан залуучуудын сурч боловсрох, хүмүүжиж төлөвших тааламжтай орчин бүрдэнэ.
- Үндэсний их сургуулиудын сургалт, судалгааны орчин нөхцөл, ашиглалт сайжирна.
- Сургалтын мэргэжлийн давхардал арилж, бүтэц оновчтой болж, зах зээлийн эрэлтэд нийцсэн тогтолцоо бий болно.
- Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэл-бизнесийн холбоо бодитой хэрэгжиж эхэлнэ.
- Монгол Улсын өрсөлдөх чадвар, эдийн засгийн өсөлтийг хангах суурь нөхцөл сайжирна.

### 3. Campus сүлжээний үйлчилгээнүүд

#### 3.1 Сүлжээний холболт

Хүснэгт 3.1 Сүлжээний холболт	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	IT үйлчилгээнүүдийг удирдуулах campus сүлжээний физик холболтын хангамж.
<b>Хэрэглэх боломж</b>	Сургуулиуд ба их сургуулийн үйлчилгээнүүдийн бүх чадамж
<b>Үйлчилгээний</b>	IT үйлчилгээнүүд нь тохирох сүлжээний гаралт ба CSV46,

<b>ТҮВШИН</b>	<p>ITS47 эсвэл CSV75IT хэлбэрийн тохирох бүрдлээр зөвшөөрөгдсөн өндөр ашиг тус өгөх сүлжээний холболт агуулна.</p> <p>Сүлжээний холболтын шаардлага нь стандартын дагуу албан газрын цагийг бүрэн төлөвлөх ба нийтэд хүлээн зөвшөөрөгдсөнөөр дунджаар ажлын 5 өдөр дотор багтаан стандартын дагуу нөхцөл байдлыг бүрэн төлөвлөх.</p> <p>Бүх ажлын шаардлагыг төсөвт ижил тусгах ба баримтын хэв журмыг хатуу гүйцэлдүүлэх. Холболтын тоо хэмжээ их юм уу эсвэл бусад стандарт бус нөхцөл байдлын асуудлыг IT үйлчилгээнүүд ба хэрэглэгчийн хооронд тусгай хэлэлцээрээр тохиролцох.</p> <p>Энэ үйлчилгээ нь зөвхөн Coventry Их сургуулийн Кампусд агуулагддаг. Үйлчилгээ ба дэмжлэг нь зөвхөн стандарт албаны цагт агуулагддаг.</p>
<b>Зөвшөөрөл бүрэн эрх</b>	Тэнхимий эрхлэгч, захирал ба их сургуулийн урирдлага
<b>Хэрэглэгчийн журмууд</b>	CSV46, ITS47 эсвэл CSV75 хэлбэрүүд нь техникийн зохистой холбоогоор бүрдсэн байх. Эдгээрийг Үйлчилгээний салбарт өргөн барьсан байх ёстой.

### 3.2 PC Workstation үйлчилгээ

Хүснэгт 3.2 PC Workstation үйлчилгээ	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Их сургуулийн сүлжээнд холбогдсон PC –ын тайлан мэдээллээр хангах болон хэрэглэгч бүрэн эрхтэйгээр бүх үйлчилгээг хэрэглэж чадна
<b>Ашиглагдах байдал</b>	Бүх салбарууд /Сургуулиудад
<b>Дутагдалтай тал</b>	Бүх хэрэглэгч бүрэн эрхтэйгээр тайлан мэдээнд хандах боломжтой.
<b>Нөхцөл байдал/Хэрэглэх шаардлага</b>	Их сургуулийн дүрмийг дагах бөгөөд удирдлагын хууль тогтоомж ба ямар нэг ажиллагааны зааварчилгааг IT үйлчилгээнүүдээр хуваасан

<b>Үйлчилгээнд зориулсан урьдчилсан нөхцөл</b>	Ажилчид дараалсан удирдлагаар эрх олгогдсон байх ба сурагчид урьдчилсан бүртгэл данстай байх ёстой. Найдвартай үйлчилгээнүүдэд зориулж PC эсвэл найдвартай ITS –н хандалтыг тохируулсан зохион байгуулалттай PC –тэй байх ёстой.
<b>Үйлчилгээг хангах түвшин</b>	Салбар ба Сургууль: PC –ын хангалт нь гол хөрөнгө төсөвлөлтөөс хамаарах. Энэ нь сургуулийн дотоод зохицуулалтаар гүйцэтгэгдэнэ.  Үйлчилгээнүүд: Энд удирдлага суурилуулалтын бүх үйлчилгээ багтсан.  Оюутнууд(ITS –д удирдагдах зөвхөн нээлттэй хандах өрөөнүүд): PC ашиглан цагийн хуваарь зохиох. Ямар нэг тоног төхөөрөмжийн удирдлагын бүх үйлчилгээгээр хангах.
<b>Үйлчилгээг сэргээн засах түвшин</b>	Тогтоосон 5 өдөрт юм уу эсвэл даруйхан ITS –р зохицуулах ба техникийн үйлчилгээний компаниар гүйцэтгүүлэх.
<b>Хэрэглэгчийн горим</b>	<ul style="list-style-type: none"> <li>· Ажилчдын бүртгэл</li> <li>· Ажилчдын сургалт</li> <li>· Сурагчдын бүртгэл</li> <li>· Student сургалт</li> <li>· Тайлангийн асуудал</li> <li>· Стандарт бус шаардлагууд</li> </ul>
<b>ITS горим</b>	<ul style="list-style-type: none"> <li>· PC –г стандартад оруулах</li> <li>· Шинэ ажилтанг PC –р хангах</li> <li>· Техникийн үйлчилгээний хуваарь</li> <li>· PC –н техникийн үйлчилгээг дэмжигч компани</li> <li>· PC –н баталгааг зохицуулах</li> <li>· Стандарт бус тохиргооны зөвлөгөө хангамж</li> </ul>



	<ul style="list-style-type: none"> <li>· Оюутны сургалтын хөтөч</li> <li>· Ажилчдын сургалтын хөтөч</li> </ul>
--	--

### 3.3 Хэрэглэгч бүртгэлийн үйлчилгээ

Хүснэгт 3.3 Хэрэглэгч бүртгэлийн үйлчилгээ	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Их сургуулийн сүлжээний үйлчилгээнүүдийн хандалтаар хангах.
<b>Хэрэглэх боломж</b>	Их сургуулийн бүх ажилчид сурагчид болон гуравдагч талуудад зөвшөөрөгдсөн.
<b>Үйлчилгээний түвшин</b>	Сурагчдын бүртгэлийн үйлчилгээ нь бүх өдөр, өдөр бүр бөгөөд шуурхай үйлчилгээ үзүүлнэ. Ажилчид болон гуравдагч талуудын бүртгэл нь ажлын жирийн цагуудад боломжтой.
<b>Нөхцөл байдал/Шаардлагууд</b>	Зөвхөн их сургуульд бүртгэлтэй оюутнуудад боломжтой Түр зуурын данс тооцоонууд нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал
<b>Зөвшөөрөл бүрэн эрх</b>	Ердийн хандалт – ажилчдад зориулсан зөвшөөрөл Оюутнуудын сургалтын бүртгэл Гуравдагч талуудад зориулсан ITS –н дарга Найдвартай хандалт - Ажилчдад зориулсан дараалсан удирдлага. Гуравдагч талуудад зориулсан ITS –н дарга.

### 3.4 UNIX/Linux тоног төхөөрөмжүүд

Хүснэгт 3.4 UNIX/Linux тоног төхөөрөмжүүд	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Unix/ Linux серверүүдийг удирдах ITS –н хандалт
<b>Хэрэглэх боломж</b>	Аливаа бүртгэлтэй хэрэглэгч

<b>Үйлчилгээний түвшин</b>	Үйлчилгээний бүх эсвэл зарим нь магадгүй хичээлийн цагийн үед боломжгүй юм.
<b>Нөхцөл байдал/Шаардлагууд</b>	Урирдлагын хууль тогтоомж
<b>Зөвшөөрөл бүрэн эрх</b>	Бүртгэлтэй хэрэглэгчид үйлчилгээнд хамрагдах

### 3.5 Campus хэвлэл (оюутнуудад зориулсан)

Хүснэгт 3.5 Campus хэвлэл	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Campus –н хааяагүй байх нээлттэй хандах өрөөнөөс А4 –дээр хэвлэх боломж. (Ихэнхдээ хар цагаанаар)
<b>Ашиглагдах байдал</b>	Зөвхөн бүртгэлтэй оюутнуудад - өөрийн ажилчдад хэрэглэхийг зөвшөөрөх
<b>Үйлчилгээний түвшин</b>	7 хоногийн 24 цагийн турш хэрэглэх боломжтой хэдий ч магадгүй эрсдэлтэй байх талтай.  Хэвлэх ажил нь магадгүй ITS PC –ээс хэвлэх ба дараа нь ямар нэгэн ITS хэвлэлийн хэсэг рүү илгээгдэж тэндээс хэвлэгддэг.
<b>Доголдол</b>	Нээлттэй хандах өрөө нь цаг үргэлж нээлттэй байх.
<b>Нөхцөл байдал/Хэрэглээний шаардлагууд</b>	None
<b>Үйлчилгээний урьдчилсан нөхцөл</b>	IT үйлчилгээг хэрэглэх тайлан мэдээлэл

### 3.6 Их сургуулийн цахим мэйл

Хүснэгт 3.6 Их сургуулийн цахим мэйл	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Их сургууль нь е-мэйл хүлээн авах ба илгээхийг хэрэглэгчдэд зөвшөөрдөг е-мэйлийн бүртгэлээр хангадаг.  Е-мэйл Антант, хаягийн жагсаалт, групп хэлэлцүүлэг болон Outlook функцүүдийг зэрэг нэмэлт хэрэгсэл оруулах.
<b>Хэрэглэх боломж</b>	Бүх бүртгэлтэй хэрэглэгчид

<b>Үйлчилгээний түвшин</b>	<p>Ерөнхийдөө бүх цагт боломжтой.</p> <p>Магадгүй зарим e-мэйл хаягийн хандалтыг блоклоно.</p> <p>Бүх шинээр ирж буй e-мэйлийн асуудал нь вирусыг шалгах ба спам илрүүлэх</p> <p>Оюутны e-мэйлийн хэмжээ нь 100MB</p> <p>Ажилчдын e-мэйлийн хэмжээ нь 400 MB</p> <p>Мессэжний хамгийн их хэмжээ нь 20MB</p>
<b>Нөхцөл байдал /Шаардлагууд</b>	Удирдлагын хууль тогтоомж ба Хэрэглэгчийн үйлчилгээний бүртгэл.
<b>Зөвшөөрөл бүрэн эрх</b>	Бүртгэлтэй хэрэглэгчид үйлчилгээнд хамрагдах

### 3.7 Campus телефон утасны үйлчилгээ

<b>Хүснэгт 3.7 Campus телефон утасны үйлчилгээ</b>	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Их сургууль телефон утасны сүлжээнд холбогдсоноор “voicemail”. “ярианы удирдлага”, “удирдлагын үйлчилгээнүүд” –г оруулж болно.
<b>Ашиглагдах байдал</b>	Салбар, Сургууль болон үйлчилгээнүүд
<b>Үйлчилгээний түвшин</b>	Сүжээний холболтын шаардлага нь бүрэн төлөвлөсөн, тухайн нөхцөл байдлыг стандартын дагуу , дунджаар 3 -5 долоо хоногийн дотор бүрэн гүйцэтгэх.
<b>Доголдол</b>	Voicemail нь хязгаарлагдмал үйлчилгээ
<b>Нөхцөл байдал/шаардлагууд</b>	Ажилчид эсвэл оюутнуудын зөвшөөрөл.
<b>Үйлчилгээнд зориулсан урьдчилсан нөхцөл</b>	Телефон утасны төсөв

### 3.8 Campus Wireless үйлчилгээ

Хүснэгт 3.8 Campus Wireless үйлчилгээ	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Утасгүй сүлжээний үйлчилгээ нь олны өмнө хандалт нь нээлттэй ба их сургуулийн интернетийн нөөц боломж юм.
<b>Боломж</b>	Их сургуулийн бүх бүртгэлтэй хэрэглэгчид (ажилчид ба оюутнууд)
<b>Үйлчилгээний түвшин</b>	<p>Бүхий л цагт боломжтой хэдий ч цаг хугацааны хувьд эрсдэлтэй</p> <p>Гаднаас хандах хандалтыг магадгүй блоклох.</p> <p>WAPs нь campus –н эргэн тойронд өөр өөр цэгүүдэд байрлах бөгөөд ямар нэг байрлалын хэрэглэгчээс өгөх ачааллаас гүйцэтгэл нь үнэлэгдэнэ. (гүйцэтгэл нь хувьсамтгай байдаг)</p>
<b>Нөхцөл байдал/Шаардлагууд</b>	<p>Зөвхөн их сургуульд бүртгэлтэй ажилчид болон оюутнууд хэрэглэх боломжтой.</p> <p>Хэрэглэгчид удирдлагын хууль тогтоомжоор хязгаарлагдана.</p> <p>Үйлчилгээ нь 802.11g ба 802.11b утасгүй холбооны стандартууд, Windows XP ба Centrino техник хангамжаар батлагдсан байх. Бусад системүүд 802.11g/b стандартуудыг ажиллагааг дэмжин ажиллах чадвартай ч баталгаагүй ба иймэрхүү системүүдийг дэмждэггүй.</p>

### 3.9 Удирдлагын үйлчилгээнүүд

Хүснэгт 3.9 Удирдлагын үйлчилгээнүүд	
<b>Үйлчилгээний тодорхойлолт</b>	Их сургуулийн бүх ажилчид, оюутнуудын удирдлага. Тэдгээрийн телефон утасны дугаар болон e-мэйл хаягийг оролцуулна.
<b>Үйлчилгээний түвшин</b>	10 секундийн дотор хайж хариу өгөх ёстой
<b>Доголдол</b>	Зарим хэрэгсэл нь зөвхөн их сургуулийн гишүүнд боломжтой.

<b>Нөхцөл байдал/Хэрэглэх шаардлагууд</b>	None
<b>Үйлчилгээний урьдчилсан нөхцөл</b>	Их сургууль вэб хуудсуудад хандах

#### 4. Кампус сүлжээний загварчлал


##### 4.1 Сүлжээг загварчлах зарчмууд болон загваруудын талаар

##### 4.1.1 Загварын зарчмууд

Сүлжээний хөгжлийн явцад сүлжээний ажиллах хугацааны циклийг тодорхойлохдоо PDIOO гэсэн нэр томъёг ашигладаг.

- Plan phase / төлөвлөлтийн үе/ - сүлжээний шаардлагыг нарийн тодорхойлох, байгаа сүлжээгээ анализ хийж дүгнэсэн байх.
- Design phase / загварчлалын үе/ - эхний шаардлагыг хангасан мөн байгаа сүлжээн дээрээ анализ хийх явцад цуглуулсан нэмэлт өгөгдлөөр сүлжээг зохион байгуулах. Сүлжээний загварыг хэрэглэгч талаар хянаж боловсруулна.
- Implement / Гүйцэтгэлийн үе/ - зөвшөөрөгдсөн загварын дагуу сүлжээг бодитоор байгуулна.
- Operate / Ажиллагааны үе/ - сүлжээний ажиллагааны явцад хяналтыг гүйцэтгэнэ. Энэ үед сүлжээний загварын эцсийн шалгалтыг гүйцэтгэнэ.
- Optimize phase / ажиллагааг сайжруулах үе/ - хяналтын явцад алдаа илэрхээс өмнө мөн илэрсний дараа алдаа дутагдлыг засварлаж шийдвэрлэнэ. Асуудлын хэмжээ хэт их байвал сүлжээний загварыг ахин гүйцэтгэнэ.
- Retirement phase / сүлжээний ажиллагааг зогсоох үе/ - сүлжээг бүрэн шинэчилсэн цаашид ямар нэг ашиглалтгүй болох.

Зураг 4.1-т PDIOO сүлжээний амьдрах хугацааны циклийг дүрсэлж үзүүлээ.




Зураг 4.1 PDIOO сүлжээний амьдрах хугацааны цикл.

PDIOO нь сүлжээний ажиллах хуцааны бүх циклийг тодорхойлдог. Сүлжээний загварыг гүйцэтгэх нь сүлжээний ажиллах хугацааны циклийн салшгүй нэг хэсэг бөгөөд бусад үеүүдэд чухал нөлөөтэй байдаг. Жишээ нь гүйцэтгэлийн үед сүлжээний загварын эх загварыг ашигладаг бөгөөд энэ үед сүлжээний загвар цаашид хүчин төгөлдөр болгоход тусалдаг.

Сүлжээг загварчлахад дараах үйлдлүүд багтана. Үүнд:

- Шаардлагыг тодорхойлох
- Хэрвээ ашиглаж байгаа сүлжээ байгаа бол түүн дээрээ анализ хийх
- Урьдчилан загварыг бэлтгэх
- Сүүлийн загварыг хэрэгжүүлэх
- Сүлжээг хөгжүүлэх
- Шаардлагатай бол дахин зохион байгуулах ба хяналтыг гүйцэтгэх
- Баримтжуулах



Зураг 4.2 Сүлжээний загварчлалын үеийн процесс.

### Шаардлагуудыг тодорхойлох

Сүлжээний шаардлагыг тодорхойлох нь PDIOO төлөвлөлийн үеийн нэг хэсэг юм. Техникийн болон бизнесийн бүх төрлийн шаардлагыг авч үзэх ёстой. Мөн сүлжээний загварын хязгаарлагч хүчин зүйлсүүдийг ч мэдэх шаардлагатай.

Техникийн шаардлага болон хязгаарлагч хүчин зүйлс. Үүнд:

- Сүлжээн дээр ажиллаж байгаа хэрэглээнүүд
- Шаардлагатай интернет холболтууд
- Хаягийн хүрэлцээгүй байдал
- IPv6 хаягийг дэмжих
- Сүлжээн дээр ажиллаж байгаа бусад протоколууд / замчлалын/
- Кабелийн шаардлага
- Нөөцийн шаардлага
- Үйлдвэрлэгчийн төхөөрөмж болон протоколуудын ашиглалт
- Цаашид ашиглах боломжтой байгаа сүлжээний төхөөрөмж



- Шаардлагатай сүлжээний үйлчилгээ / үйлчилгээний чанар болон утасгүй технологи оруулах/
- Сүлжээгээр дамжиж байгаа бүрэн бүтэн байдлыг хэрхэн хангах
- Шаардлагатай сүлжээний шийдлүүд
- Сүлжээний удирдлага Шинэ технологиудаар хуучин хэрэглээг дэмжих
- Зурвасын өргөны боломж

Бизнесийн шаардлага болон хязгаарлагч хүчин зүйлс. Үүнд:

- Төсөв / шинэ төхөөрөмжид зориулсан/ болон гүйцэтгэлийн зардал
- Хуваарь: хуучин хэрэглээнүүдийг үйлчилгээнээс гаргах, шинэ хөлсний ажилчдыг түрээслэх г.м
- Ажиллах хүч: сүлжээг суурилуулах, ажиллуулах хүмүүсийн ямар чадвартай байх, ямар сургалт шаардлагатай. Тэднийг сургахад ямар нэг гадаад эх үүсвэр шаардлагатай эсэх г.м
- Хууль: цуглуулсан өгөгдлийн хадгалалт, ашиглалтын хязгаарлалт болон байгууллагын үүрэг хариуцлага
- Түүх: байгаа сүлжээний бүтцийг шалгах, өөрчлөлтийг эсэргүүцэх хүмүүс байгаа эсэхийг тодорхойлох
- Бодлого: одоогийн байгууллагын бодлого сүлжээний өөрчлөгдөх боломжийг хязгаарлах эсэх

### **Байгаа сүлжээн дээрээ анализ хийх**

Одоогийн сүлжээгээ шинэслэх гэж байгаа бол сүлжээгээ анализ хийх шаарлагатай. Байгаа сүлжээ нь шинэ загварт хориг саад учруулж болзошгүй. Жишээ нь ашиглаж байгаа кабель нь сайн биш байж болно. Гэхдээ эдийн засгийн байдлаас шалтгаалж өөрчлөөгүй байж болно. Байгаа сүлжээний анализыг тухайн сүлжээний ажиллагааг сайжруулах үед гүйцэтгэнэ. Энэ нь шинэ сүлжээний төлөвлөгөөний үеийн нэг хэсэг болдог. Юу нь сайн бэ? Аль хэсгийг нь өөрчлөх шаарлагатай вэ гэдгийг тодорхойлохдоо сүлжээгээ анализ хийх шаардлагатай.

### **Эх загварыг бэлтгэх / урьдчилан/**

Үүнийг бэлтгэхэд сүлжээний бүх шаардлагууд, хязгаарлагдмал хүчин зүйлс / төсөв г.м/, ашиг тустай шинэлэг санаануудыг оруулдаг. Сүлжээний эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр хамтдаа сайн шийдлийг сонгоно. Сонгосон шийдлээ эцсийн загвар болгож хөгжүүлнэ. Эх загварын болон эцсийн загвар PDIOO –н загварчлалын үед хийгддэг. Сүлжээний загварт 2 арга хэрэглэдэг.

1. Top –down арга
2. Bottom-up арга

Top-down аргад сүлжээний загварын шаардлага нэн түрүүнд сүлжээн дээр ажиллаж байгаа хэрэглээнүүдийг судалж авч үздэг.

Bottom-up аргын хувьд нэн түрүүнд төхөөрмж, кабель г.м зүйлийг авч үздэг. Үүнийг сүлжээн дээр ажиллаж байгаа хэрэглээнээ нийцүүлдэг. Энэ аргыг сүлжээний хэрэглээг өөрчлөхгүйгээр сүлжээг дахин шинэчлэхэд ашигладаг. Энэ аргыг

ашигласнаар шаардлагагүй нэмэлт төхөөрөмж суурилуулснаар эдийн засгийн хувьд хохиролтой байх боломжтой.

### **Эцсийн загварыг хэрэгжүүлэх**

Энэ үед гүйцэтгэлийн үед шаардлагатай сүлжээний зураг, тусгай тохиргоонууд, үнэ, хаягчлалын төлөвлөгөө, бусад мэдээллүүд г.м зүйлүүдийг бүгдийг нь багтаана.

### **Сүлжээний хөгжүүлэлт**

Сүлжээний хөгжүүлэлт нь төлөвлөгөө болон хуваарьтайгаар эхлэх ёстой. PDIOO –н загварчлалын үе нь хөгжүүлэлтийн төлөвлөгөөгөөр эхэлж гүйцэтгэлийн үеэр үргэлжилдэг. Хөгжүүлэлтийн төлөвлөгөөнд юу, хэрхэн яаж хийгдэх ёстойг дэлгэрэнгүй тусгасан байх шаардлагатай. Зөвхөн хийгдэх боломжтой зүйлс бус хийгдэх боломжгүй зүйлсийн хийгдэх боломжийг тодорхойлох шаардлагатай.

### **Хяналтыг гүйцэтгэх болон дахин зохион байгуулах**

Сүлжээг ажиллуусны дараа сүлжээний суурь үзүүлэлтийг олж мэдэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл сүлжээний ажиллагааны статистикийг тодорхойлох юм. Мөн сүлжээний асуудлуудыг хянаж тодорхойлох хэрэгтэй. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй ахин зохион байгуулах шаардлагатай эсвэл эзэмшигчийн зүгээс тавигдаж байгаа шаардлага өөрчлөгдсөн, нэмэгдсэн тохиолдолд тохирсон сүлжээний загварын өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Үүнийг гүйцэтгэхэд дээр дурьдсан сүлжээний загварын бүх боловсруулалтыг дахин гүйцэтгэх шаардлагатай. Үүнийг PDIOO –н ажиллагааны болон ажиллагааг сайжруулах үед ахин зохион байгуулах шаардлагатай үед төлөвлөгөө болон загварчлалын үе рүү буцна.

### **Загварыг баримтжуулах**

Баримтанд дараах зүйлсийг оруулна. Үүнд:

- Бүх шаардлагууд болон хязгаарлагч хүчин зүйлс
- Байгаа сүлжээний төлөв
- Урьдчилсан сүлжээний загварын сонголтууд, эцсийн загварыг хэрхэн сонгосон талаар товч мэдээлэл
- Эцсийн загварын талаар дэлгэрэнгүй мэдээлэл
- Эх загварын сүлжээний шалгалтын үр дүн
- Хөгжүүлэлтийн төлөвлөгөө, хуваарь бусад гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй
- Хяналт шалгалтын шаардлага
- Бусад ажил хэргийн талаарх мэдээлэл


#### **4.1.2 Модуль загвар**

Модуль гэдэг нь бүхэл хэсгийн бүрэлдэхүүн хэсэг юм. Сүлжээний модуль загвар нь сүлжээний бүх шаардлагуудыг хангасан тус бүрийн үүрэгтэй янз бүрийн хэмжээтэй модуль хэсгүүдээс тогтсон байдаг. Модуль бүрийг загварчлах нь сүлжээг бүхэлд нь загварчлахаас илүү хялбар байдаг. Модуль бүр нь өөр хоорондоо холбоотой

ажилладаг. Модулийн өөрчлөлт нь бусад модульд нөлөөлөхгүй.


Сүлжээг загварчлахад сүлжээний шаталсан загварыг өргөнөөр ашигладаг. Сүлжээний шаталсан загварыг ажиллагааных нь хувьд гурван модуль болгож хуваадаг.

- Access – төгсгөлийн хэрэглэгчийн сүлжээний хандалтыг хангадаг
- Distribution – дэд сүлжээний хоорондын холболтыг хангадаг
- Core – distribution түвшний төхөөрөмж хооронд өндөр хурдны холболтоор хангадаг



Зураг 4.3 Сүлжээний шаталсан загвар.

#### 4.1.3 Enterprise загвар



Зураг 4.4 Campus –н жишээ загвар

**Campus архитектур**

Campus архитектурт дэмшилтэт технологийн switching болон routing –н голлох дэд бүтцийг гүйцэтгэдэг. Үүнд:

- IP Communications
- Mobility
- Advanced security

**Campus архитектурын онцлогууд:**

- Уян хатан multilayer загварчлалтай
- Нөөц техник болон програм хангамжийн бүрэлдэхүүн хэсэгтэй
- Алдаа гарахад сүлжээний нөөц замыг автоматаар тохируулах боломжтой
- Зурвасын өргөний ашиглалтыг сайжруулах multicast дамжуулалтыг дэмждэг
- Сүлжээний атак (worms, viruses) –аас сэргийлэхэд сүлжээний портын түвшинд шийддэг
- Яриа дүрс гэх мэт бодит хугацааны өгөгдлийг хүлээлтгүй уналтгүй дамжуулах QoS мяханизмыг дэмждэг
- Хэрэглэгчийн authentication –г 802.1x болон Extensible Authentication Protocol(EAP) протоколуудыг ашигладаг
- IPsec болон Multiprotocol Label Switching virtual private networks (MPLS VPNs) –г дэмждэг
- Хандалтыг тусгаарлах VLAN –г дэмждэг

Дээр дурьдсан онцлогууд нь нууцлал болон ажиллагааг сайжруулах, үнийг бууруулах боломж олгодог.

**Data Center архитектур**

Өгөгдлийн төв нь нягтарсан , уян хатан сүлжээний бүтэцтэй. Дараах онцлогуудыг дэмждэг.

- Хоёр болон хэд хэдэн байгууллагын бизнесийн болон IT –ийн шаардлагыг хангасан
- Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангасан
- Нууцлалыг хангасан

**Branch архитектур**

Салбар нь төв салбарын хэрэглээнүүд болон үйлчилгээг өргөтгөх боломжийг олгодог. Үүнд:

- Нууцлал
- IP суурьтай холболтууд
- Мянга мянган алсын хандалттай хэрэглэгчийг дэмжих
- Боломжтой дэвшилтэт applications

**Teleworker архитектур**

Teleworker бүтэц нь алсын жижиг эсвэл гэрийн сүлжээ рүү стандарт өргөн зурвасын хандалтын үйлчилгээг ашиглан нууцлалтайгаар яриа болон өгөгдлийг дамжуулах

боломжийг олгодог. Үүнд :


- Нууцлалтайгаар log on хийж ханддаг
- Always-on VPNs технологийг ашигладаг

### WAN архитектур

WAN бүтэц нь портын ганц IP холболтын сүлжээгээр яриа, дүрс болог өгөгдлийн үйлчилгээг нэгтгэж дамжуулах боломж олгодог. Үүнд:

- Боломжийн үнээр дамжуулах
- Байршил хамааралгүй төрөл бүрийн өгөгдлийг нууцлалтайгаар дамжуулах
- MPLS. VPN

#### 4.1.4 Их сургуулийн сүлжээний ерөнхий загвар




- - Server node
- - Network node

Зураг 4.6 Их сургуулийн campus –н ерөнхий архитектур загвар.

1. Лекцийн танхим
2. Спорт заал
3. Удирдлагын хэсэг
4. Хоолны танхим
5. Хурлын танхим

6. Оюутны байр
7. Номын сан
8. Эрдэм шинжилгээ лабарторын танхим
9. Клуб, амралт чөлөөт цагийн хэсэг



Зураг 4.8 Campus –н ерөнхий сүлжээний загвар